



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/27

Амардалай

Г Түүхт 100 жилийн ном бүтээх ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Сумын 100 жилийн ой 2023 онд тохиох болсонтой холбогдуулан “Дэлгэрцогт түүхт 100 жил” ном бүтээх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Сармандах (Архив, бичиг хэргийн ажилтан)

Аймаг болон уугуул иргэдийн материал бүрдүүлэх ажлын хэсэг:

Н.Эрдэнэ-Очир (Аймаг дахь нутгийн зөвлөлийн дарга)

Н.Майхүү (Аймгийн нутгийн зөвлөлийн гишүүн)

Б.Эрдэнэцэцэг (ЕБСургуулийн номын санч)

Суманд дахь иргэдийн материал бүрдүүлэх ажлын хэсэг:


Ж.Наранцэцэг (Ахмадын хорооны дарга)

Ю.Дашдаваа (ЕБСургуулийн багш)

С.Оюунтуяа (Соёлын төвийн номын санч)

Хоёр.Номонд оруулах ард иргэдийн материалыг нэгдсэн фонд, файл үүсгэж, фото зураг бусад материалыг чанарын шаардлага хангахуйц хэмжээнд бүрдүүлж, эх бэлтгэлийн газарт тухай бүр хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Сумын 100 жилийн ойн номны зардалд өгөх иргэд аж ахуй нэгжийн хандивыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу сумын орон нутгийн дэргэдэх хөгжлийн санд төвлөрүүлж, олон нийтэд танилцуулахыг Соёлын төв, сангууд хариуцсан нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) д үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880800320